



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

### Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын төр, шашин, соёл урлагийн нэрт зүтгэлтэн Өндөр гэгээн Г.Занабазарын мэндэлсний 390 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, нэгдсэн удирдлага, зохин байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т, дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ч.НОМИН

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 200 дугаар тогтоолын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Гишүүд: -Гадаад харилцааны сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
- Өвөрхангай аймгийн Засаг дарга;
- Сэлэнгэ аймгийн Засаг дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Соёл, урлагийн газрын дарга;
- Чингис хаан үндэсний музейн захирал;
- Үндэсний урлагийн их театрын захирал;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал (тохиролцсоноор);
- Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Хамба лам (тохиролцсоноор);
- Монголын соёл, яруу найргийн академийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);

Нарийн бичгийн  
дарга

-Монголын үндэсний спортын нэгдсэн хорооны  
ерөнхийлөгч (тохиролцсоноор).

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн  
ёслолын газрын дарга;

-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын  
яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга.

----o0o----